



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/199

Хужирт сум

Жилийн эцсийн мал тооллогын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Засгийн газрын 2003 оны "Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай" 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Ичинхоролцэвэлмаа (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Б.Доржсэмбэ (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Алтансүх (Цагдаагийн тасгийн дарга)

Б.Пагамдулам (1 дүгээр багийн Засаг дарга)

С.Самдан (2 дугаар багийн Засаг дарга)

Т.Даваадорж (3 дугаар багийн Засаг дарга)

Д.Мягмарсүрэн (4 дүгээр багийн Засаг дарга)

Ц.Лхамролом (5 дугаар багийн Засаг дарга)

Ц.Амгалан (6 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Бямбасүрэн (Статистик хариуцсан мэргэжилтэн)

2. Мал тооллогын ажлыг багуудад зохион байгуулах салбар комиссуудын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хяналтын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар, тээврийн хэрэгсэл, бензин шатахууны хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх ажилд шаардагдах төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

622301399

D:Alban bichig;Zahiramj 2023